



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 6 сарын 5 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Мэдээллийн технологийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 28.1.7 дугаар зүйл, Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, "Цахим Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Эрдэмнет сүлжээний ашиглалтыг сайжруулах шаардлага, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Нэгжийн дарга нарын зөвлөлийн 2007 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн мэдээллийн технологийн бааз, багшлах боловсон хүчинтэй холбоотой статистик мэдээ, тайлангийн үзүүлэлтийг шинээр боловсруулан батлуулах, "Цахим Монгол" хөтөлбөрийн хэрэгжилт, боловсролын салбарт мэдээллийн технологи хэрхэн нэвтэрч байгаа үйл ажиллагааны явцад жил бүр мониторинг хийж, дүнг танилцуулж байхыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/-т даалгасугай.

2. Эрдэмнет сүлжээнд төрийн өмчийн боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудыг бүрэн хамруулах асуудлыг судлаж шийдвэрлэх, сүлжээний үйл ажиллагааг өргөтгөх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, сүлжээний хурдыг дээшлүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах, өртөгийг бууруулах арга хэмжээ авахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/, Санхүү, эдийн засгийн газар /Ц.Даваасүрэн/, Эрдэмнет сүлжээ /А.Эрдэнэбаатар/ болон холбогдох газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Эрдэмнет сүлжээнд тус тусын сургуулийг 2007 онд багтаан холбох арга хэмжээ авахыг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирлуудад даалгасугай.

4. Эрдэмнет сүлжээнд өөрийн сургуулийг холбох арга хэмжээ авах талаар төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн захирлуудад зөвлөмж болгосугай.

5. Боловсролын байгууллагуудын электрон номын сангийн нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг судлан 2007 оны 9 дүгээр сард багтаан танилцуулахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/, Соёл урлагийн газар /Г.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

6.Дотоодын их, дээд сургууль, коллежийн зайн сургалтыг хамарсан Е-сургуулийг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бүрэлдэхүүнд байгуулах арга хэмжээ авахыг тус сургуулийн захирал /Б.Дамдинсүрэн/-д даалгасугай.

7.Төрийн өмчийн бүх шатны сургуулийн компьютерийн засвар үйлчилгээний төвийг Шинжлэх ухаан технологийн их сургууль дээр байгуулсугай.

8.Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэдээллийн технологийн лаборатори, танхимд тавигдах стандарт, шаардлагыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлуулахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

9.Төрийн өмчийн бүх шатны сургуулийг хямд өртөг бүхий, чанартай компьютер, дагалдах хэрэгсэлээр хангах, багш нарыг компьютержүүлэх менежментийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх санал боловсруулж, 2007 оны 11 дүгээр сард Сайдын зөвлөлд танилцуулахыг Санхүү, эдийн засгийн газар /Ц.Даваасүрэн/-т даалгасугай.

10.Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг мэдээллийн технологийн багшаар хангах, тэдний англи хэл, мэдээллийн технологийн мэдлэгийн түвшинг тогтоож, үе шаттайгаар мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлж ажиллах, энэ үйл ажиллагаанд дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагын туслалцаа авах чиглэлээр ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Д.Эрдэнэчимэг/-т болон их, дээд сургууль, коллежийн захирлуудад тус тус даалгасугай.

11.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг нэгдсэн сүлжээнд холбож, вэб хуудастай болгох, вэб хуудсаар дамжуулж мэргэжлийн сурталчилгааг сайжруулах арга хэмжээ авахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/, Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/, Боловсролын хөгжлийн хөтөлбөр /Р. Бандий/-т тус тус даалгасугай.

12.Сургуулийнхаа интернет сүлжээний хурдыг сайжруулах, багш, оюутан, сурагчдын мэдээллийн технологийн мэдлэг, түүнийг ашиглах ур чадвар, интернет сүлжээний ашиглалтыг сайжруулах, компьютер, дагалдах хэрэгсэл, программ хангамжийн тоо, чанарыг сайжруулахад анхаарч ажиллахыг бүх шатны сургуулиудын захирлуудад үүрэг болгосугай.

13.Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамыг Эрдэмнэт сүлжээнд холбох асуудлыг судлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/-т, холбогдох зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн газар /Ц.Даваасүрэн/-т тус тус даалгасугай.



САЙД

Ө.ЭНХТҮВШИН